



Хүндэт эцэг эх / асран хамгаалагч танаа,

Саяхан танай хүүхдээс *Бичиг Үсгийн Үндсэн Ур Чадварын Динамик Үзүүлэлт (DIBELS)* тест авсан. DIBELS нь сурагчдын унших үр чадварыг тодорхойлоход багш нар болон сургуулиудад тусламж үзүүлдэг аргачлал юм. Эхэн уншлагыг амжилттай буюу үр дүнтэй хийхэд авиалбар буюу фонемик ойлголт, авиа зүй, чөлөөтэй унших чадвар, үсгийн сан, уншаад ойлгох чадвар зэрэг үндсэн үр чадварууд шаардлагатай. Доорх хүснэгтэнд агуулагдаж буй эцэг эхчүүдэд өгсөн DIBELS үнэлгээ хийх зааварчилгаа нь сурагчийн дүнгийн түвшинд үндэслэн сурагчаас авсан DIBELS тестийн дагуу тодорхойлсон үр чадварууд болон DIBELS аргыг харуулсан болно.

DIBELS тестээс авсан сурагчийн оноо нь тухайн сурагчийг амжилттай буюу үр дүнтэй уншихад үр чадварын хувьд зөв түвшинд байгаа эсэх талаар мэдээлэл өгдөг. Та сурагчийн хэсэг тус бүрээс авсан оноо болон голч оноо (DIBELS тестийн хэсэг тус бүрээс авсан онооны нийлбэр), түүнчлэн авсан оноо нь энэхүү захианд хавсаргасан *2020-2021 Эцэг эхчүүдэд өгөх мэдэгдэл: DIBELS 8-р хэвлэл* дэх сурагчийн жилийн эхэн дэх дүнгийн үзүүлэлттэй хэрхэн харьцуулагдаж буйг харж болно. **Голч оноонд үндэслэн унших үр чадвартай холбоотой бүхий л эрсдлийг маш сайн урьдчилан таамаглах боломжтой байдаг.** Эцэг эхчүүдэд өгөх мэдэгдэлд эрсдлийн ангиллыг өнгөөр ялган кодолсон байх ба дараах хүснэгт нь өнгийн кодчиллыг эрсдлийн ангилалтай уялдуулсан байна.

Зорилгоос нэлээд доогуур Эрсдэлтэй/Дэмжлэг их шаардлагатай	Зорилгоос доогуур Зарим талаараа эрсдэлтэй/Стратегийн дэмжлэг хэрэгтэй	Зорилгод хүрсэн Бага зэргийн эрсдэлтэй/ Үндсэн дэмжлэг хэрэгтэй	Зорилгоос дээгүүр Маш бага эрсдэлтэй/ Үндсэн дэмжлэг хэрэгтэй
----------------------------------------------------------------------	----------------------------------------------------------------------------------	---------------------------------------------------------------------------	-------------------------------------------------------------------------

DIBELS тестийн үр дүнг сурагчийн суралцах зорилгыг тодорхойлох, зорилтот заах арга зүйг төлөвлөхөд дэмжлэг үзүүлэх, сурагчийн ахиц дэвшлийг хянах, унших суурь үр чадварт нь нэмэлт дэмжлэг тусалцаа үзүүлэх шаардлагатай сурагчдын мэдлэг ойлголтыг сайжруулахад ашиглаж байна.

Хүндэтгэсэн,

Арлингтоны Дэмжлэг Үзүүлэх Шаталсан Тогтолцоо/Англи Хэлний Ур Чадварын Хөтөлбөр/Тусгай Боловсролын Газар
Сургалтын Алба

DIBELS үнэлгээ хийх тухай эцэг эгчүүдэд өгөх зааварчилгаа

Унших чадвар	Энэ нь юу вэ? Яагаад чухал вэ?	DIBELS аргачлал	Өгсөн дүнгийн түвшин					
			К	1	2	3	4-6	7-8
Фонемик ойлголт	Фонемик ойлголт гэдэг нь таны хүүхдийн үгэн дэх авиаг сонсох, ашиглах чадварыг хэлнэ.	Эхний авиаг таних чадвар	✓					



Department of Teaching and Learning- 2110 Washington Boulevard ·Arlington, Virginia 22204

		Авиаг задлах чадвар	✓	✓				
Авиа зүй	Авиа зүй гэдэг нь ярианы хэлэн дэх дан авиануудыг ялган сурч, тухайн авиаг англи хэлний үсэг болгон бичиж болгон буулгах чадварыг хэлнэ.	Утга илэрхийлдэггүй үг унших чадвар Үг унших чадвар	✓ ✓	✓ ✓	✓ ✓	✓ ✓		
Чөлөөтэй унших чадвар	Чөлөөтэй унших чадвар гэдэг нь таны хүүхдийн текстийг үнэн зөвөөр, автоматаар буюу шууд унших чадварыг хэлдэг бөгөөд энэ чадварын тусламжтайгаар сурагчид уншиж байгаа зүйлээ ойлгодог.	Амаар унших чадвар Үг унших чадвар	✓ ✓	✓ ✓	✓ ✓	✓ ✓	✓ ✓	
Уншаад ойлгох чадвар	Уншаад ойлгох гэдэг нь таны хүүхэд уншиж байгаа зүйлээ ойлгох чадварыг хэлнэ. Энэ нь унших ур чадварыг заахын туйлын зорилго юм.	Ээдрээтэй Тодорхойгүй			✓ ✓	✓ ✓	✓ ✓	
Үсэг нэрлэх чадвар нь сурагчийн Англи хэлний цагаан толгой дахь том жижиг үсгүүдийг “нэрлэж” хэлэх чадварыг хэлнэ.		Үсэг нэрлэх чадвар	✓	✓				